

САЙХАН УЛАМЖЛАЛ, ГЭЭЖ БОЛШГҮЙ ӨВ

*П.Нямаа**

Одоогоос 55 жилийн тэртээ Монгол Улс Зүүн болон Төв Европын тэр үед ардчилсан орнууд гэгдэж байсан хэд хэдэн шинэ залуу улсуудтай дипломат харилцаа тогтоосон билээ. Манай орны хувьд энэ нь улс төрийн нэн чухал үйл явдал байсан бөгөөд Монгол Улс тухайн үеийн түгжигдмэл байдлаасаа олон улсын тавцан дээр гарах цоо шинэ түүхэн алхам байв.

1950 оны 4-р сарын 25-нд хуучин нэрээр БНМАУ, БНЧСУ дипломат харилцаа тогтоосон нь манай хоёр орны хооронд улс төр, худалдаа-эдийн засаг, соёлын харилцаа, хамтын ажиллагааны бусад салбар хөгжих өргөн боломж, хэтийн төлвийг нээсэн юм. Эдгээр нь манай хоёр ард түмний таашаалд нийцсэн, зоригийг бадруулсан чухал эхлэл болсныг тэмдэглүүштэй.

Манай хоёр ард түмэн хэдийгээр Ази, Европт алслагдан амьдарч байдаг ч бурханы ерөөлөөр ойртон сууж буурал түүхээ хамтран бичилцэх учир тавилантай бус уу. Бүр эртний түүхийн эх сурвалжийн хуудсуудаас хоромхон зуур сөхөхөд монгол хүмүүс эзэн Чингэсийн үеэс эх дэлхийд гарч Дунай мөрний эрэг хүрч явахдаа Бат хааны цэрэг / 1350-иад он/ Чех нутагт хүрч Морава голыг гаталж явжээ. Энэхэн зуур сонирхуулахад Моравын томоохон хот Оломоуцыг “Олом ус” гэсэн монгол үгнээс гаралтай гэж ярьдаг юм билээ. Энэ бүхэн тэр цагийн ааш араншинд хамаатай ч анх Монгол, Чех, Словак хүмүүс нүүр учирч байсны үл мөр биз. Эртний улбаатай энэ явдлууд цааш цаашдаа эх дэлхийд эе эвийг эрхэмлэх, эрх тэгш хамтран аж төрөх, саараар бус сайнаар бие биеэ танин мэдэх, ойртон ойлголцох, улмаар орчин цагийн гольдролд орж даяаршлын эрэн цагтай золгох нэгэн сайхан бэлэг дэмбэрэлтэй байжээ.

Манай улс, ард түмэн Чех болон Словакийг хэзээнээс нааш хүндэтгэн түүний хүн ард нь юугаараа гайхамшигтай, юу хийж чаддаг, юу нь бидний сэтгэл зүрхэнд ойрхон байдгийг мэддэг, эрхэмлэн дотночилж явдаг билээ. Карл IV хааны холч мэргэн төрийн бодлого, гүн ухаантан Ян Гусын өөрчлөн шинэтгэх зоригт тэмүүлэл, алдарт уран үгсийн мастер А.Ирасек, Б.Немцова нарын ард түмнээ хайрласан сэтгэл, В.Сметана, А.Дворжакийн уянгалаг дуу хөгжим, Я.Гашекийн

*П.Нямаа - 1991-1995 онуудад Монгол Улсаас Чех болон Словак улсад Элчин сайдаар ажиллаж байсан ахмад дипломатч

хөгжилтэй цэргийн хөгтэй явдлууд, Д.Сүхбаатарын сонинд сэтгүүлч хүний хувьд өгсөн дэмжлэг, Прагийн хөгжимт хавар, 1968 оны дуулиант хавруудыг санан дурсахын хамт саяхан Чех, Словак улс Европын Холбоонд өөрийн байр суурийг эзлэх болсонд гүн талархаж байна. Энэ бүхэн бид, Монгол Улс Европт улам ойртох, түүний улс орнуудтай ойр дотно түншлэх, хамтран ажиллах бодлого, хүсэл сонирхлын маань үүд хаалга болно гэж найдаж байна. Монгол, Чехословакийн уламжлалт олон талын харилцаа, хамтын ажиллагаа 1950-иад оноос худалдаа, 1955 онд монгол оюутнууд анх Чехословакт явж суралцах болсон цагаас соёл боловсрол, 1960-аад оны эхнээс эдийн засаг-техник, шинжлэх ухааны салбарт өргөжин тэлснээр тодорхойлогдоно.

1960-аад оноос хоёр талын эдийн засгийн харилцаа нь хамтын ажиллагааны хууль эрх зүйд тулгуурлан гэрээ хэлэлцээрийн олон хэлбэрээр хөгжиж ирсэн. Тэр үеэс хоёр талын худалдаа зээл санхүү, техник-эдийн засгийн хамтын ажиллагаа хоёр улсын Засгийн газар хоорондын болон дараа нь ЭЗХТЗ-ийн хүрээнд өргөжиж, Чехословак улс манай орны гадаад том түншийн хувьд 2-3-р байр эзэлдэг байлаа. Монгол орны уул уурхай, геологи хайгуулын ажилд чех, словак мэргэжилтнүүд орос хүмүүсийн зэрэгцээ хүчин зүтгэж Эрдэнэтийн овоог товлон тодорхойлох их ажлыг хийсэн. Үүнд Мөрөнд төвтэй инж. М.Краутерын удирдсан экспедиц том үүрэг гүйцэтгэж билээ. Хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны нэг ширгэшгүй ундрага нь Чех болон Словакт төрөл бүрийн мэргэжил эзэмшсэн 300 гаруй дээд боловсролтой, эрдмийн зэрэг хамгаалсан 30 гаруй хүн, Чехийн Злин Сазава дахь Зруч, Либерец, Пардубице, У.Храдиште, Словакийн Партазанске, Бановце, Прага, Братислова зэрэг газруудад ТМС төгссөн, мэргэжил эзэмшсэн олон зуун охид хөвгүүд билээ. Эд нар Монгол-Чех, Монгол-Словакийн ард түмний найрамдал, хамтын ажиллагааны уламжлалыг шинэ цаг үед ч үргэлжлүүлэн дэлгэрүүлэх нь дамжиггүй. Хоёр талын гэгээрэл, хүмүүнлэгийн харилцааг хөгжүүлэхэд эрдэмтэд, зохиолчид, тэдний бүтээлүүд чухал үүрэг гүйцэтгэж байна. Бүр 50-иад оны эхээр Чехийн нэрт эрдэмтэн судлаач др. Павел Поуха “Монголын нууц товчоог” чех хэлнээ хөрвүүлж, өөрөө их эрдэмтэн Б.Ренчиний хамт аялсан “13000 км Монгол нутгаар” нэртэй аян замын тэмдэглэлээ нийтэлсэн юм. Мөн Б.Ренчиний “Үүрийн туяа” Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” болон Ч.Ойдов, Ч.Чимэд, Н.Банзрагч, Б.Явуухулан, Т.Очирхүү зэрэг манай нэрт зохиолчдын олон бүтээл чех хэлнээ орчуулагдсан байна.

Эдгээр бүтээлүүдийг орчуулах болон Монголын түүх, хэл соёл, урын санг судлах, өөрийн ард түмэнд хүргэх талаар монголч эрдэмтэн др. Иржи Шима одоо ч гэсэн маш идэвх зүтгэлтэй ажиллаж байна. Энэ хүн бол зөвхөн эрдэмтэн-судлаач төдийгүй бас нийгмийн идэвхтэй зүтгэлтэн, улс төрч-дипломатч, монголд чин үнэнч сэтгэлтэй нэгэн. Др. И.Шима “Монголын анд нөхдийн нийгэмлэг”-ийг 20 шахам жил тэргүүлэхдээ улирал бүр Монголын тухай олон хуудастай, анхаарал татсан сонин агуулгатай мэдээ мэдээлэлийг тогтмол гаргаж байна. Тэрээр “Монгол гэр” нэртэй өдөрлөгүүдийг жил бүр Чех, Словакийн хотуудад зохиож, талархагчид, дэмжигчдээ урин оролцуулдаг сайхан заншилтай болжээ. “Монголын анд нөхдийн нийгэмлэг” энэ жил хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойг угтан тэмдэглэх, ирэх 5-р сард Чехийн Парламент дахь Чех-Монголын бүлгэмийн оролцоо дэмжлэгтэйгээр Монголын өдрүүд, бага хурал, уулзалт, аялал зохион байгуулах, Монголоос зочин төлөөлөгчид урих ажил зохиохоор бэлтгэж байна. Харамсалтай нь манай тал ийм сайхан сэтгэл, зүтгэл, эрч хүчийг гаргахгүй байна. Монгол-Чех, Монгол-Словакийн хооронд соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан мэдээлэл харилцааны ажил өргөн дэлгэр, өгөөж нөлөө ихтэй хөгжиж ирсэн. Урлагийн том, жижиг хамтлагууд, уран зураг, дуу хөгжмийн болон кино фестивалд оролцсон хүмүүсийн тоо олон мянгаар тооцогдоно. Энэ сайхан уламжлал цаашид ч өсөх нь дамжиггүй.

Монгол-Чехийн, Монгол-Словакийн харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд нэг үеийг бодвол сэргэх төлөвтэй шинэ шинэ алхам хийгдэж байна. Энэ талаар хоёр улсын засаг төр анхаарал тавьж байна. 1990-ээд оны эхэнд Чех болон Словак хоёр улсын тусгаар тогтнолын үед бидний харилцаа зогсонги байдалд орсон нь цаг үеийн бодит үнэн. Иймд үед бид Прага дахь ЭСЯ-аа татан аваагүй. Харин Чех улс нэг талын алхам хийсэн юм. Иймэрхүү тэнцвэргүй, үл ойлгогдох байдал үүсээд байгааг би элчин сайд байсны хувьд тэр үеийн Чех улсын Засгийн газрын дарга, одоогийн ерөнхийлөгч Вацлав Клауст хандаж хэлэхэд “Энэ бол манай бодлогогүй хүмүүсийн болчимгүй бодлого доо. Бид үүнд санаа зовж байгаа” гэж билээ.

Одоо хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны шинэ үе эхэлжээ. Энэ бол том өөрчлөлт, баттай эх суурь мөн.

Монгол, Чехийн харилцаа найдвартай уламжлал дээрээ түргэн ахих бүрэн боломжтой юм. Үүнийг сүүлийн жилүүдэд хоёр талаас авсан арга хэмжээ, тавьж буй хүчин чармайлтууд харуулж байна. Ялангуяа

1995 оноос хойш хоёр талын байгуулсан үндсэн зарчмын яриа хэлэлцээ, төр, засгийн хооронд явагдсан уулзалт айлчлалууд чухал түлхэц өгч ирлээ.

Худалдаа, гааль, хөрөнгө оруулалтын болон Чех улсаас үзүүлж буй буцалтгүй, хөнгөлөлттэй тусламжийн олон арга хэмжээ чухал үүрэг гүйцэтгэж байна.

Ялангуяа манай улсын хөдөө аж ахуйн салбар, дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчны болон уул уурхайн чиглэл дэх хоёр талын хамтын ажиллагаа үр өгөөжөө өгөх нь дамжиггүй.

Чех, Словак улсын эдийн засаг-санхүү, техник-технологийн дэмжлэг тусалцаатайгаар манай улсад гутал, арьс шир, цемент, эмнэлэг, эрчим хүч, холбооны зэрэг олон үйлдвэр аж ахуйн газар байгуулагдсан, олон жил үр шимээ өгч байсан, өгч ч буй. Үүний сацуу бид Чехословакт нэлээд өртэй байсан. Уг өрийн дарамтыг Чехийн Засгийн газар бидний мөрнөөс хэлтлэн буулгасан учрыг мэдэх хүмүүс, ард түмэн маань туйлын баяртай байдаг.

Өнөөгийн байдлаар Чех улс Төв болон Зүүн Европын орнууд дотроос манайтай санхүү, эдийн засгийн талаар хамгийн эрчимтэй харилцаж байгаа орон юм. Энэ бүхнийг Чех улсаас манай оронд үзүүлж буй буцалтгүй тусламж, Монгол Улсыг хөгжлийн тусламж үзүүлэх орнуудын тоонд оруулсан зэргээс нь харж болно.

Би энд олон тоо баримт тоочиж судалгаа зэрэгцүүлэлт хийхийг зорьсонгүй.

Найрсаг Чех, Словакийн ард түмэн түүний засаг төрд энэ тэмдэглэлт ойг тохиолдуулан хамгийн сайхан бүхнийг хүсэн ерөөе.